

TAX AND LEGAL ALERT

Mongolia • Issue 02/2020 • March 2020

AML/CFT regime broadens its scope to non-financial business consultants

Contacts:

Michael Ahern

Partner & TLS Leader
michael.ahern@pwc.com

Tsendmaa Choijamts

Executive Director, Tax and Legal Services
tsendmaa.choijamts@pwc.com

Maryna Tarnavska

Senior Manager, Tax and Legal Services
tarnavska.maryna@pwc.com

Munkhjargal Ragchaakhuu

Senior Legal Consultant
munkhjargal.ragchaakhuu@pwc.com

PwC Tax TMZ LLC

Central Tower 6th floor
Suite 603, Ulaanbaatar
14200, Mongolia
Tel : + 976 70009089
Fax : +976 11 322068

www.pwc.com/mn

This Alert is produced by PwC Tax TMZ LLC. The material contained in this alert is provided for general information purposes only and does not contain a comprehensive analysis of each item described. Before taking (or not taking) any action, readers should seek professional advice specific to their situation. No liability is accepted for acts or omissions taken in reliance upon the contents of this alert.

© 2020 PricewaterhouseCoopers Tax TMZ LLC. All rights reserved. In this document, "PwC" refers to PricewaterhouseCoopers Tax TMZ LLC, which is a member firm of PricewaterhouseCoopers International Limited, each member firm of which is a separate legal entity.



On 17 January 2020, the Parliament approved amendments to the Law of Mongolia on Combating Money Laundering and Financing of Terrorism

On 17 January 2020, the Law of Mongolia on Combating Money Laundering and Financing of Terrorism (the “**AML Law**”) was amended to clarify the scope and roles of Designated Non-Financial Businesses and Professions in an effort to adequately comply with the Financial Action Task Force (the “**FATF**”) recommendations as Mongolia had recently been grey listed due to “strategic deficiencies” in anti-money laundering and combating the financing of terrorism (the “**AML/CFT**”) policies.

The amendment became effective immediately upon approval from 17 January 2020.

We highlight the key changes and implications as below:

1. Non-financial businesses and professions such as lawyers, accountants, tax consultants and external auditors are now obligated to disclose the extensive client information for the review of Financial Intelligence Unit (the “**FIU**”), as they are considered as reporting entities (the “**RE**”), if they have *prepared, completed or participated in the following* transactions exceeding MNT 20 million (or foreign currency equivalent) in relation to their clients:



Selling and purchasing of real estate



Asset management



Managing of banks, savings and securities accounts



Incorporating a company to raise or source funds for the purpose of maintaining and managing its operations



Establishing a legal entity, managing its operations, or conducting certain activities upon agreements or selling or buying business entities.

Before the said amendments, these non-financial businesses and professions were not subject to the AML Law unless they have conducted the aforementioned transactions on behalf of the client.

TAX AND LEGAL ALERT

Mongolia • Issue 02/2020 • March 2020

2. The Non-financial businesses and professions are obliged to conduct a stringent due diligence on clients' transactions and report certain transactions to the FIU.

In particular, all REs, including auditors, tax consultants and accountants will either report or collect and maintain their client data with one of the following elements (so called "suspicious transactions"):

- Politically Exposed Person involved
- Sudden increase in the transaction value
- No apparent economic or legal grounds
- Transactions made through AML/CTF sanctioned countries.

Conducting a customer due diligence by REs means an obligation for their clients to **disclose** and **provide more detailed information** in respect of their **ultimate beneficial owners** (the "UBO"), **purpose of transactions** and **organizational structures**.

3. In light of strengthening the REs' functions and obligations under the AML Law, the following business activities are now required to obtain relevant licenses or permits:

Activities/businesses	Type of permit	License/permit issuer
Real estate brokerage	License	FRC
Precious metal shops	License	FRC
Accounting services	Permit	Mongolian Institute for Chartered Public Accountants

The license/permit issuers are responsible for ensuring the proper implementation of the new AML/CFT regime by the license/permit holders as REs under the FIU's supervision and monitoring.

4. Under the AML Law, the designated non-financial business and professions are immune from a non-disclosure and confidentiality of clients' privilege. Thus, they will report to the FIU and maintain the customer data without disclosing to the customer and in doing so, no legal obligation will be imposed on REs.

5. REs are also required to keep records of the mentioned client data for at least 5 years for the FIU to review it annually for compliance.

What should be expected?

Businesses will be required to prepare and maintain information in respect of their UBOs, shareholding structures as well as organizational structures and to update it regularly since many service providers became REs.

A significant scale of inspections may be conducted on REs' compliance with the AML Law by key regulators such as the FIU and license issuers.

REs are required to refrain from providing services if their clients refused to supply the required information.

In general, businesses operating in Mongolia may anticipate a more restrictive compliance regime as a result of the amendments.

Should you have further inquiries and question in relation to the AML/CFT compliance, please do not hesitate to contact us.

ТАТВАР БОЛОН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улс • Дугаар 02/2020 • 2020 оны 3-р сар

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх зохицуулалтууд санхүүгийн бус бизнесийн зөвлөхүүдэд хамаарах болж хүрээ нь өргөжлөө

Холбоо барих:

Майк Ахэрн

Партнер, Татвар, Хуулийн зөвлөх
үйлчилгээ
michael.ahern@kz.pwc.com

Чойжамцын Цэндмаа

Гүйцэтгэх захирал, Татвар, Хуулийн
зөвлөх үйлчилгээ
tsendmaa.choijamts@mn.pwc.com

Марина Тарнавска

Ахлах Менежер, Татвар, Хуулийн
зөвлөх үйлчилгээ
tarnavska.maryna@mn.pwc.com

Рэгчаахүүгийн Мөнхжаргал

Хуулийн Ахлах Зөвлөх
munkhjargal.ragchaakhuu@pwc.com

Прайсуотерхаускүперс Такс ТМЗ ХХК

Сентрал Тауэр, 6 давхар
603 тоот, Улаанбаатар
14200, Монгол Улс
Утас: + 976 70009089
Факс: +976 11 322068

www.pwc.com/mn

Энэхүү мэдээллийг PwC Такс ТМЗ ХХК-аас бэлтгэсэн болно. Энэ мэдээлэлд багтсан материал нь зөвхөн ерөнхий мэдээллийн зорилготой бөгөөд энд тусгасан асуудал бүрээр олон талын, цогц шинжилсэн мэдээллийг агуулаагүй болно. Аливаа үйлдэл хийх (эс үйлдэх)-ээс өмнө үүнийг уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон тусгайлан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгыг ашигласан үйлдэл, алдаа хийдлээс гарах аливаа хариуцлагыг бид хариуцахгүй болно.

© 2019 PricewaterhouseCoopers Tax TMZ LLC.

All rights reserved. In this document, "PwC" refers to PricewaterhouseCoopers Tax TMZ LLC, which is a member firm of PricewaterhouseCoopers International Limited, each member firm of which is a separate legal entity.



Улсын Их Хурал 2020 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг баталлаа

Монгол Улс саяхан мөнгө угаахтай тэмцэх болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ("МУ/ТСТ") бодлогын хувьд "стратегийн дутагдал"-тай гэж үнэлэгдсэнээс улбаалан саарал жагсаалтад орсон. Улмаар Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах байгууллагын ("ФАТФ") зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор 2020 оны дүгээр сарын 17-ны өдөр Монгол Улсын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд ("МУТСТ хууль") нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд тус хуулиар зарим санхүүгийн бус бизнесийн зөвлөхүүд болон мэргэжилтнүүдийн хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхой болголоо. Энэхүү нэмэлт өөрчлөлт нь батлагдсан өдрөөсөө буюу 2020 оны 1-р сарын 17-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн юм.

Бидний зүгээс энэхүү хуульд орсон гол өөрчлөлтүүд болон тэдгээрийн үр дагаварт дараах байдлаар тодруулга хийж байна. Үүнд:

1. Хуульч, нягтлан бодогч, татварын зөвлөх, хараат бус аудиторууд гэх мэт санхүүгийн бус бизнесийн зөвлөхүүдийг дараах тохиолдолд Мэдээлэх үүрэгтэй этгээд ("МУЭ")-ийн ангилалд оруулсан байна. Эдгээр МУЭ нь өөрсдийн харилцагчийн 20 сая төгрөг (эсхүл түүнтэй тэнцэх гадаад валют)-аас дээш үнийн дүн бүхий дараах ажил, гүйлгээг бэлтгэсэн, хийсэн эсхүл хийхэд оролцсон бол хяналт тавих зорилгоор Санхүүгийн мэдээллийн алба ("СМА")-нд харилцагчтай холбоотой өргөн хүрээний мэдээллийг гаргаж өгөх үүрэгтэй болж байна. Үүнд:



Үл хөдлөх хөрөнгө
худалдах, худалдан авах



Харилцагчийн хөрөнгийг
удирдах



Банкны, хадгаламжийн,
үнэт цаасны дансыг
удирдах



Компанийг үүсгэн байгуулах,
түүний үйл ажиллагааг явуулах,
удирдахад зориулан хөрөнгө татах,
бүрдүүлэхийг зохион байгуулах



Хуулийн этгээдийг үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагааг явуулах, удирдах, эсхүл хэлцлийн үндсэн дээр аливаа тодорхой үйл ажиллагаа явуулах, удирдах, эсхүл аж ахуйн нэгжийг худалдах, худалдан авах

ТАТВАР БОЛОН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улс • Дугаар 02/2020 • 2020 оны 3-р сар

Энэхүү нэмэлт өөрчлөлтүүдээс өмнө харилцагчийн нэрийн өмнөөс дээр дурдсан үйл ажиллагааг явуулсан тохиолдолд л эдгээр санхүүгийн бус бизнесийн зөвлөхүүд болон мэргэжилтнүүд нь МУТСТ хуулийн үйлчлэх хүрээнд хамаарч байв.

2. Санхүүгийн бус бизнесийн зөвлөхүүд болон мэргэжилтнүүд өөрсдийн харилцагчдын гүйлгээнд шаардлагатай тохиолдолд тусгай хяналт тавьж, зарим хэлцлүүдийг СМА-д тайлагнах үүрэгтэй болж байна.

Ялангуяа аудиторуд, татварын зөвлөхүүд, нягтлан бодогчид зэрэг бүх МҮЭ-үүд дараах нөхцлүүдийн аль нэгийг агуулсан ажил, гүйлгээ байгаа бол тухайн гүйлгээнд холбогдох ("сэжигтэй гүйлгээ" гэх) харилцагчийн мэдээллийг мэдээлэх эсхүл цуглуулан хадгалах юм. Үүнд:

- Улс төрд нөлөө бүхий этгээд оролцсон
- Хэлцэл нь огцом өөрчлөгдсөн их дүнтэй
- Эдийн засаг, хууль зүйн илт үндэслэлгүй
- МУ/ТСТ хяналтын тогтолцоо хангалтгүй гэж тодорхойлогдсон улсаар дамжуулан хийгдсэн.

МҮЭ зүгээс харилцагчийг таньж мэдэх ажиллагаа явуулах болсоноор тэдний харилцагчдийн хувьд өөрсдийн Эцсийн өмчлөгч ("ЭӨ"), **хийж буй хэлцлийн зорилго, байгууллагын бүтцийн талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл гаргаж өгөх үүрэгтэй болж байна** гэсэн үг юм.

3. МУТСТ хуулийн дагуу МҮЭ-ийн чиг үүрэг болон бусад үүргийн хэрэгжилтийг хянах шаардлагатай холбогдуулан дараах аж ахуйн үйл ажиллагааг явуулахын тулд эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрөл, бусад зөвшөөрлийг авах шинэ шаардлага бий болж байна. Үүнд:

Үйл ажиллагааны чиглэл	Зөвшөөрлийн төрөл	Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл олгогч
Үл хөдлөх хөрөнгө зуучлал	Тусгай зөвшөөрөл	СЗХ
Үнэт чулуу, металлын арилжаа	Тусгай зөвшөөрөл	СЗХ
Нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ	Зөвшөөрөл	Монголын мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох институт

Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл олгогчид нь СМА-ны хяналтан дор тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл эзэмшигчид болох МҮЭ-ээр дамжуулан МУТСТ хуулийн шинэ шаардлагыг хэрэгжүүлэх үүрэг хүлээж байна..

4. Зөвлөх үйлчилгээ үзүүлэгчид нь үйлчлүүлэгчийн гүйлгээний мэдээллийг МУТСТ хуулийн дагуу эрх бүхий байгууллагад мэдээлэх нь тэднийг харилцагчийн нууцыг задруулсанд тооцохгүй бөгөөд холбогдох хариуцлагаас чөлөөлөгдөх талаарх хамгаалалт бүхий зохицуулалт МУТСТ хуульд заасан байна.

5. МҮЭ нь мөн харилцагчийн хуульд заасан гүйлгээний талаарх мэдээлэл, бусад холбогдох баримтуудыг тухайн гүйлгээ хийгдсэнээс хойш 5-аас доошгүй жилийн хугацаанд хадгалах үүрэг хүлээж байна.

Хууль хэрэгжиж эхэлснээр бий болох үр дагавар?

Ихэнхи бизнесийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгчид МҮЭ-д хамаарах болсон тул бизнес эрхлэгчид өөрсдийн эцсийн өмчлөгч, хувьцаа эзэмшигчийн бүтэц, байгууллагын бүтцийн талаархи мэдээллийг бэлтгэх, хадгалах, түүнийг тухай бүр тогтмол шинэчлэх, мэдээллийг үнэн зөвөөр гаргаж өгөх шаардлагатай болов.

МҮЭ-ийн МУТСТ хуулийг дагаж мөрдөж буйтай холбоотойгоор СМА, тусгай зөвшөөрөл олгогч зэрэг хяналт тавих эрх бүхий байгууллагуудаас хийх хяналт шалгалтын тоо нэлээдгүй нэмэгдэх шинжтэй байна.

МҮЭ-ийн харилцагч нь шаардлагатай мэдээллийг өгөхөөс татгалзсан тохиолдолд МҮЭ нь тухайн харилцагчид үйлчилгээ үзүүлэхээс татгалзах шаардлага тавигдаж байна.

Ерөнхийдөө, энэхүү нэмэлт өөрчлөлттэй холбогдуулан, Монголд үйл ажиллагаа явуулж буй бизнес эрхлэгчдийн хувьд МУТСТ-ийн зохицуулалтууд илүү мэдрэгдэж, дагаж мөрдөх шаардлага өргөн хүргээнд тавигдаж байна.

Энэхүү мэдээлэлд дурдсан МУ/ТСТ-ийн нийцэлтэй холбоотой асуудлаар нэмж тодруулах зүйл байвал бидэнтэй холбогдоно уу.